

## ДААТГАЛЫН МЭДЭЭ

2009 ОНЫ 10 ДУГААР САР

### 1. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:


Даатгалын компаниудын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2009 оны 10 дугаар сарын байдлаар харуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд : /төгрөгөөр/

	Үзүүлэлт	2009-IX	2009-X	Өөрчлөлт /хувиар/
1	Даатгалын нийт хураамж	1,687,824,860.26	1,598,526,212.42	-5.29
2	Олгосон нийт нөхөн төлбөр	494,006,180.81	392,846,843.87	-20.48
3	Давхар даатгалд төлсөн хураамж	755,714,131.47	613,250,920.00	-18.85
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	4,708.00	5,201.00	10.47
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	7,140,000,000.00	16,917,643,340.89	
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	70,455,840.00	43,347,824.79	

2009 оны 10 дугаар сарын даатгалын хураамжийн орлого 9 дүгээр сарынхаас 5.29 хувиар, олгосон нөхөн төлбөр 20.48 хувиар буурсан байна. Байгуулсан даатгалын гэрээний тоо нэмэгдсэн хэдий ч даатгалын хураамж болон давхар даатгалын хураамж буурсан байгаа нь даатгалын компаниуд хураамж багатай даатгалын гэрээнүүд хийсэн гэж үзэхээр байна.

## Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн харьцаа



Даатгалын компаниудаас 10 дугаар сард хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийг “Бодь даатгал” ХХК нь “Ийзинис Эйрвэйз” ХХК-ийн агаарын хөлгийн даатгалын гэрээний нөхөн төлбөрт 43.3 сая төгрөг олгосон байна.

### Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2009-IX	2009-X	Өөрчлөлт
1	Даатгалын нийт хураамж	5,346,703.52	11,088,123.00	5,741,419.48
2	Олгосон нийт нөхөн төлбөр	632,000.00	1,000,000.00	368,000.00
3	Давхар даатгалд төлсөн хураамж	-	3,816,265.50	3,816,265.50
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	9 гэрээ	19 гэрээ	10 гэрээ
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	30,000,000.00	20,000,000.00	
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	480,000.00	1,000,000.00	

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн даатгалын хураамжийн орлого 10 дугаар сард 9 дүгээр сарынхаас 5.7 сая төгрөгөөр, даатгалын гэрээний тоо 10-аар, нөхөн төлбөр 368.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байна.

10 дугаар сард хийгдсэн даатгалын гэрээнүүдээс “Хувь хүний хугацаат амьдралын даатгал”-ын гэрээ 17, “Байгууллагын хугацаат амьдралын даатгал”-ын гэрээ 2 байна. Гэнэтийн осол, эмнэлгийн мөнгө нэмэлт нөхцөлөөр 1.0 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна.